



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ  
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ**

Нам Ян Жугийн гудамж 32/1,  
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13335  
Утас: 45 39 94, Факс: (976-11) 45 86 99,  
Цахим шуудан: info@nccd.gov.mn,  
Цахим хуудас: www.nccd.gov.mn

2026.02.16 № 3-4/202.

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ТӨВ  
ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВ,  
АЙМАГ НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗАР, БОЭТ, НЭГДСЭН ЭМНЭЛГҮҮД, МЯЭ,  
ШШҮХ, АШУУИС, АЧ АНГАНААХ УХААНЫ  
ИХ СУРГУУЛЬ, ЭТҮГЭН ИХ СУРГУУЛЬ,  
ШИНЭ АНАГААХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ,  
ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭМНЭЛЭГ,  
ЛАБОРАТОРИУДЫН ДАРГА НАРТ "-Д

Эрүүл мэндийн лабораторийн  
мэргэжилтний 7 хоног арга хэмжээнд оролцуулах  
болон эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн  
хураангуй ирүүлэх тухай

Халдварт өвчинтэй тэмцэж эхэлсэн анхны нэгж байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд "Эрүүл мэндийн лабораторийн мэргэжилтний 7 хоног" сэдэвт арга хэмжээг Монгол Улсад дөрөв дэх удаагаа 2026 оны 04 дүгээр сарын 30-наас 05 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулахаар болсон.

Энэхүү арга хэмжээ нь эрүүл мэндийн лабораторийн салбарт ажиллаж буй эмч, био-анагаахын судлаач, мэргэжилтэн, лабораторийн техникч, мэргэжил дээшлүүлэх болон төрөлжсөн сургалтад хамрагдаж буй суралцагчид, түүнчлэн эрүүл мэндийн бусад салбарын эмч, мэргэжилтэн, судлаачдыг хамарсан өргөн хүрээтэй, олон талт хөтөлбөртэйгээр зохион байгуулна.

Иймд Та бүхнийг байгууллагынхаа эмч, багш, судлаач, лабораторийн мэргэжилтэн, суралцагчдыг уг арга хэмжээнд идэвхтэй оролцуулахыг хүндэтгэлтэйгээр урьж байна.

Арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдах эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлэх илтгэлийн хураангуйг 2026 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийг хүртэл Nccd.NLA@nccd.gov.mn цахим хаягаар хүлээн авна.

"Эрүүл мэндийн лабораторийн мэргэжилтний 7 хоног" арга хэмжээний урьдчилсан хөтөлбөрийн мэдээлэл болон илтгэлийн хураангуйд тавигдах шаардлагыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: хуудас

Зохион байгуулагч: ХӨСҮТ-ийн Нэгдсэн лабораторийн алба

Үргэлжлэх хугацаа: 2026.04.30-2026.05.02 (Зөдөр)

Олгох багц цаг: 2.5 кредит

Хүлээн авах хаяг: Nccd.NLA@nccd.gov.mn

Холбоо барих: Н.Буяндэлгэр – 98059991Б, Бумдэлгэр – 80456624

ЗАХИРАЛ



С. ЭНХБОЛД

Халдварт өвчин судлалын үндэсний  
төвийн ерөнхий захирлын 2026 оны  
дугаартай албан бичгийн хавсралт



**Үндэслэл**

Олон улсад 1957 оноос хойш жил бүрийн дөрөвдүгээр сарын сүүлийн долоо хоногийг "Эрүүл мэндийн лабораторийн мэргэжилтэний 7 хоног" сэдвийн дор уламжлал болгон зохион байгуулсаар ирсэн. Халдварт өвчинтэй тэмцэж эхэлсэн анхны нэгж байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд "Эрүүл мэндийн лабораторийн мэргэжилтэний 7 хоног" сэдэвт арга хэмжээг Монгол улсад 4 дэх удаа 2026 оны 04 дүгээр сарын 30-наас 05 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулахаар болсон.

**Зорилго**

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх, лабораторийн үйл ажиллагаа, шинэ дэвшилтэд технологи, инновацийг танилцуулах, мэргэжилтнүүдийн мэдлэг чадавхийг сайжруулах

**Зорилт**

Дээрх зорилтын хүрээнд эрүүл мэндийн эрүүл мэндийн лабораторийн салбарт ажиллаж буй эмч, мэргэжилтнүүдийн дунд:

1. Сургалт
2. Семинар
3. Эрдэм шинжилгээний хурал
4. Нөхөрсөг арга хэмжээ зохион байгуулах (3000м алхалт гүйлт, лаборатори үзэх)

Эмнэлгийн бусад чиглэлийн эмч, мэргэжилтнүүд болон олон нийтэд

1. Лабораторийн технологийн дэвшил түүний эмнэлзүйн хэрэглээ, үйл ажиллагааг суртачлан таниулах /видео, тараах материал/

Сургалтын хэлбэр: Лекц, семинар, эрдэм шинжилгээний хурал

Хамрах хүрээ: Эрүүл мэндийн лабораторийн салбарт ажиллаж буй эмч, био-анагаах судлаач, лабораторийн техникч болон мэргэжил дээшлүүлэх, төрөлжсөн мэргэжлээр суралцаж буй суралцагчид эмнэлгийн бусад салбарын эмч мэргэжилтэн, судлаачид.

Сургалтын арга зүй:

- Нэгдсэн лекц
- Онол практикийн бага хурал
- Лабораторийн дэвшилтэд технологи танилцуулга
- Нөхөрсөг арга хэмжээ

Эрдэм шинжилгээний хурлыг

1. Хүний их эмч
2. Био-анагаах судлаач
3. Лабораторийн техникч
4. Эмнэлзүйн тохиолдол гэсэн 4 хэсэг болгон явуулна.

Шалгуур үзүүлэлт ба шагналын сан:

1-р шат:

1. Шинжлэх ухаанч байдал

2. Судалгааны бүтээлч санаа, шинэлэг тал
  3. Судалгааны ач холбогдол
  4. Хураангуй бэлтгэсэн байдал
- 2-р шат

- Үндсэн үзүүлэлт (тус бүр -10)
  1. Шинжлэх ухаанч байдалд
  2. Шинэлэг тал
  3. Ач холбогдол
- Нэмэлт үзүүлэлт (тус бүр -5)
  1. Илтгэх чадвар
  2. Илтгэл бэлтгэсэн байдал
  3. Цаг барилт
  4. Асуултанд хариулсан байдал

Нийлбэр оноо тэнцсэн тохиолдолд үндсэн үзүүлэлтийг баримтлана.  
Хурал тус бүрээс шилдэг 1 илтгэлийг шалгуулна.

Эрдэм шинжилгээний хурлын бүтээлд тавигдах ерөнхий шаардлага:

1. Илтгэлийн хураангуйг А4 цаасны 1 нүүрнээс хэтрүүлэлгүй, Arial фондоор:
  - Удиртгал
  - Зорилго
  - Материал, арга зүй
  - Үр дүн
  - Дүгнэлт, хэлцэмж гэсэн хэсгүүдийг багтаан Монгол хэл дээр бэлтгэнэ.
2. Хураангуйн гарчиг нь Arial фондоор, үсгийн хэмжээ нь 12, **Bold** хэлбэрээр бичнэ.
3. Өгүүллийг А4 хуудасны нэг талд 31 мөрөөр Arial фондоор 12-ын үсгээр бичнэ. Илтгэлийн хураангуйд хүснэгт, график, зураг оруулахгүй болохыг анхаарна уу!
4. Бичил биетний нэрийг латинаар *бичмэл шриф* (*italic*) ашиглан бичнэ.
5. Судлаачдын нэрсийн төгсгөлд харъяа байгууллагыг тодорхойлох зүүлт бичнэ.
6. Харъяа байгууллагын нэрийг бүтэн нэрээр, Arial фондоор зүүлтний дарааллын дагуу, нэр бүрийг шинэ мөрнөөс бичнэ.
7. Илтгэгчийн e-mail хаягийг бичнэ.
8. Хураангуйг word file-ийн нэр: тухайн зохиогч нь кириллээр Илтгэгчийн нэр, доогуур зураас, гарчгийг бичиж 2026 оны 04 дүгээр сарын 01-ны өдөр хүртэл [Nccd.NLA@nccd.gov.mn](mailto:Nccd.NLA@nccd.gov.mn) хаягаар илгээнэ үү.